

1 Аудитын тайлан

1.1 Оршил

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн аудитын тайланг ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны дарга С.Нацагдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд авлагыг тооцоо нийлж баталгаажуулах талаар зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.


ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний алба нь санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 12-ноос 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-ийн Ахлах аудитор С. Бямбаа, аудитор Ж. Отгонцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний алба нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 07/a-180 тоот албан бичгийн хамт “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

1.3 Байгууллагын хууль, эрх зүйн орчин



ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Авто тээврийн тухай, Иргэний нисэхийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны эрхэм зорилго иргэний нисэхийн зохицуулалт, стандартыг сайжруулах, аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтийг бататгах, аюулгүй ажиллагааны уламжлалыг өөрчлөх, үндэсний эдийн засагт хувь нэмрээ оруулах гэж тодорхойлсон байна.

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний алба нь дотоод, гадаадын авиа компаниудын агаарын хөлгүүдэд нислэгийн өмнөх болон дараах газрын иж бүрэн үйлчилгээ үзүүлдэг байна. Үүнд: Орон нутагт агаарын хөлгийн шатахууны хангалтыг зохион байгуулах, тээвэрлэлтийг гүйцэтгэх, аэродромын талбайн арчлалт хийх, цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцах, ИНЕГ-ын байгууллагуудын нийтийн болон технологийн авто тээврийн хэрэгцээг ханган, автомашин, тоног төхөөрөмж, механизмын техникийн үйлчилгээ, засварын ажил гүйцэтгэж, нислэгийн аюулгүй байдлыг найдвартай, сааталгүй явуулах боломжийг олгон ажиллаж байна.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2 дугаар зүйлд тус тус заасны дагуу ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны дарга хөрөнгийг захиран зарцуулж байна.

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан. /ТАБ-СТА-А-1/

1.5 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 13 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 1.10 дахь заалтад хураангуйлан тэмдэглэв.

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний алба нь санхүүгийн тайлан, төрийн аудитын байгууллага хангамжаар бэлтгэсэн байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

1.6 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

ИНЕГ-ын дотоод аудитын албанаас хийсэн хяналт шалгалтаар санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 0.2 сая төгрөгийн зөрчил илэрснийг залруулсан байна.

1.7 Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

ИНЕГ-н харьяа Газрын тусгай үйлчилгээний алба нь 2017 онд нийт 9,246.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 9,575.8 сая төгрөгийн зардалтай ажиллан, 329.7 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

Тус байгууллагын 2017 оны урсгал зардалд 9,091.5 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 7,874.0 сая төгрөгийг зарцуулж 13.4 хувиар төсөв хэмнэсэн байна. Өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлээс 19.5 сая төгрөгөөр буурсан.

1.8 Шилэн дансны мэдээлэл

ИНЕГ-н харьяа Газрын тусгай үйлчилгээний алба нь “Шилэн дансны тухай” хуулийн дагуу 2017 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна.

1.9 Олж тогтоосон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 13 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Санхүүгийн тайланд тооцоо нийлж баталгаажуулаагүй 120.8 сая төгрөгийн авлага, ажлаас халагдсан ажилтан 1.7 сая төгрөгийн зөөврийн компьютерыг хүлээлгэн өгөөгүй нь оршин байх батламж мэдэгдэлд нийцэхгүй байна.

1.10 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.10.1 Авлагын талаар

Тайлант онд 120.8 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2006-2016 онд үүссэн 112.9 сая төгрөгийн авлагад албан шаардлага, 2017 онд үүссэн 7.9 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллагад хандаж барагдуулах талаар зөвлөмж өгөх.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

1.10.2 Үндсэн хөрөнгийн талаар

Ажлаас халагдсан ажилтан 1.7 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютерыг хүлээлгэн өгөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр тогтов.

1.11 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татсан асуудлууд:

1. ИНЕГ-аас хөрөнгө оруулалтаар худалдан авсан 161.1 сая төгрөгийн бш фургон автомашин, 132.3 сая төгрөгийн ланд круйзер автомашиныг 2016 оны 12 сарын 31-нээр тус албаны санхүүгийн тайланд шилжүүлэн бүртгэсэн байна. Фургон автомашиныг аймгуудын Эрүүл мэндийн төв болон нийтлэг үйлчилгээний газруудад, ланд круйзер автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ашиглаж байна.

2. Системийн өглөгийн 3,953.0 сая төгрөгийг ИНЕГ-ын системийн хэмжээнд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор 2,446.0 сая төгрөгийг хуримтлагдсан үр дүн, 1,507.0 сая төгрөгийг бусад орлого дансанд хааж бичсэн байна.

1.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 оны 12 дугаар сарын 25-нд худалдан авсан 161.6 сая төгрөгийн бш фургон автомашиныг 2016 оны 12 сарын 31-нээр ИНЕГ-ын балансаас ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны балансад шилжүүлэн бүртгэсэн байна. Фургон автомашиныг Баянхонгор, Баян-Өлгий, Өмнөговь, Сэлэнгэ аймгуудын Эрүүл мэндийн төв, Говь-Алтай, Төв аймгийн Нийтлэг үйлчилгээний газруудад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 3 дугаар 28-ны 87 тоот тушаалын дагуу шилжүүлсэн байна. Гэвч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 6 сарын 13-ны 292 тоот тушаалаар хүчингүй болгосон байна. Байгууллагын удирдлага тухайн машинуудыг одоо ашиглаж буй байгууллагуудын данс бүртгэлд тусгуулах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт удаа дараа албан бичиг явуулсан байна. Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 9-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд “Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжээд УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон боловч УИХ-ын тогтоол гараагүй байна.


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү УИХ шийдвэрлэнэ” гэж заасны дагуу тус албаны бүртгэлээс хасагдаагүй байна.

2. 2016 оны 6 дугаар сарын 14-нд Сангийн сайдын 236 тоот тушаалаар Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-аас ИНЕГ-т балансаас балансад шилжиж ирсэн 132.3 сая төгрөгийн ланд круйзер автомашиныг Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ ашиглаж байна.

Уг хөрөнгүүдийн бүртгэлийн асуудлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай байна.

1.13 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

ИНЕГ-н харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 122.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 114.6 сая



төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7.9 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн.

1.14 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ИНЕГ-н харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар ажлаас халагдсаны нөхөн төлбөр, 156.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, жолооч нарын шатахуун зарцуулалтын тооцоог тогтоосон нормоор тооцоолох зэрэг 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Нийт 174.5 сая төгрөгийн зөвлөмж өгснийг 77 хувь биелүүлж ажилласан байна.

1.15 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн хэлбэлзэл өндөр байсан тул нийт зардлыг суурь болгон тооцсон.

Тус байгууллага 2016 оны санхүүгийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан, санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч нь ИНЕГ-ын салбарт 1997 оноос ажиллаж байгаа, 2017 оны ИНЕГ-ын дотоод аудитын шалгалтаар 0.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул эрсдэл бага гэж үзэж материаллаг байдлыг 2 хувиар сонгосон.

Тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 9,575.8 сая төгрөгийн 2 хувиар буюу 191.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо. Шинж чанар орчин нөхцөлөөр тооцоход материаллаг шинжтэй зүйлс илрээгүй болно.

1.16 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Зөрчилгүй санал дүгнэлт

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.





ИНЕГ-Н ХАРЬЯА ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Авлагын талаар.....8

2018 оны 2 дугаар сар



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ИНЕГ-н харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



2.1 Авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
<p><u>Аудиторын ажиглалт</u></p> <p>7.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.</p> <p><u>Эрсдэлүүд</u></p> <p>Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, найдваргүй авлага үүсэх.</p>	<p><u>Аудиторын зөвлөмж</u></p> <p>7.9 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллагад хандаж барагдуулах.</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 сарын 25-ны дотор Үндэсний Аудитын газарт хүргүүлэх.</p> <p><u>Төсвийн захирагчийн хариу</u></p> <p>Асуудлын бүртгэлийг байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан хүлээн зөвшөөрсөн болно.</p>



3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, тодруулга**3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ	-	-
Эргэлтийн хөрөнгө	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	125,972,565.92	265,390,129.25
Дансны авлага	766,014,764.78	581,407,573.41
Татвар, НДШ – ийн авлага	-	10,837,761.41
Бусад авлага	146,300,370.82	550,153,628.09
Бараа материал	734,151,707.86	847,253,883.17
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	73,000,470.82
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,772,439,409.38	2,328,043,446.15
Эргэлтийн бус хөрөнгө	-	-
Үндсэн хөрөнгө	18,824,761,832.45	21,758,560,798.24
Биет бус хөрөнгө	-	14,850,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-14,768,566,625.00	-15,362,082,920.13
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,056,195,207.45	6,411,327,878.12
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,828,634,616.83	8,739,371,324.27
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
Өр төлбөр	-	-
Татварын өр	9,271,558.15	-
Бусад богино хугацаат өр төлбөр	40,021,564.64	168,648,625.50
Системийн өглөг	2,445,980,676.55	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,495,273,799.34	168,648,625.50
Урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	2,495,273,799.34	168,648,625.50
Эздийн өмч	-	-
Хойшлогдсон орлого	-	3,121,041,885.49
Хуримтлагдсан ашиг	4,056,195,207.46	3,333,360,817.49
Тайлангийн үеийн ашиг /алдагдал	-722,834,389.97	-329,660,680.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		2,445,980,676.55
Эздийн өмчийн дүн	3,333,360,817.49	8,570,722,698.77
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,828,634,616.83	8,739,371,324.27

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Борлуулалтын орлого (Цэвэр)	7,172,084,230.12	2,881,770,536.07
Борлуулалтын өртөг	7,491,813,172.79	8,776,373,535.49
Нийт ашиг (алдагдал)	(319,728,942.67)	-5,894,602,999.42
Түрээсийн орлого	-	3,850,000.00
Хүүний орлого	-	3,587,509.00
Ногдол ашгийн орлого	-	0
Эрхийн шимтгэлийн орлого	-	0
Бусад орлого	1,234,810.06	6,356,911,970.71
Борлуулалт маркетингийн зардал	-	0
Ерөнхий ба удирдлагын зардал	57,609,235.37	147,115,357.96
Санхүүгийн зардал	-	0
Бусад зардал	346,731,022.00	591,033,469.77
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	0
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-61,258,333.33
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	0
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	0
Бусад ашиг (алдагдал)	-	0
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(722,834,389.97)	-329,660,680.77
Орлогын татварын зардал	-	0
Татварын дараах ашиг (алдагдал)	(722,834,389.97)	-329,660,680.77
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(722,834,389.97)	-329,660,680.77
Бусад дэлгэрэнгүй орлого	-	0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	0
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	0
Бусад олз гарз	-	0
Орлогын нийт дүн	-	0
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(722,834,389.97)	-329,660,680.77

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	(312,693,848.83)	(312,693,848.83)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	4,368,889,056.29	4,368,889,056.29
Залруулсан үлдэгдэл	-	-	4,056,195,207.46	4,056,195,207.46
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(722,834,389.97)	(722,834,389.97)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2016 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	-	-	3,333,360,817.49	3,333,360,817.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	2,445,980,676.55	2,445,980,676.55
Залруулсан үлдэгдэл	-	-	5,779,341,494.04	5,779,341,494.04
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(329,660,680.77)	(329,660,680.77)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2017 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	-	3,121,041,885.49	5,449,680,813.28	8,570,722,698.77

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	7,793,193,617.37	8,006,593,378.87
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,695,515,702.37	3,095,628,091.81
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	31,262,106.00	54,739,798.00
Татаас, санхүүжилтийн орлого	4,847,022,397.00	4,790,786,767.00
ҮҮА-ны бусад мөнгөн орлого	219,393,412.00	65,438,722.06
Мөнгөн зарлагын дүн (-)	7,826,784,075.47	7,869,348,324.54
Ажиллагчдад төлсөн	4,189,855,949.36	4,365,953,992.30
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,062,300,000.00	949,357,111.78
Бараа материал худалдан авахад төлсөн	263,211,262.00	143,052,595.50
Ашиглалтын зардалд төлсөн	78,922,829.62	43,588,267.64
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,327,367,592.28	1,502,995,531.17
Татварын байгууллагад төлсөн	442,500,000.00	488,578,810.47
Даатгалын төлбөрт төлсөн	39,536,443.00	201,743,445.00
ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	423,089,999.21	174,078,570.68
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(33,590,458.10)	137,245,054.33
Мөнгөн орлогын дүн (+)	1,234,810.06	3,587,509.00
Хүлээн авсан хүүний орлого	1,234,810.06	3,587,509.00
Мөнгөн зарлагын дүн (-)	39,352,700.00	1,415,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,352,700.00	1,415,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(38,117,889.94)	2,172,509.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(71,708,348.04)	139,417,563.33
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	71,708,348.04	139,417,563.33
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,680,913.96	125,972,565.92
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	125,972,565.92	265,390,129.25




3.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны гүйцэтгэл	2017 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,893,506.8	7,969,844.4	9,091,461.3	7,874,026.4	(1,217,434.9)
УРСГАЛ ЗАРДАЛ	256,365.2	228,346.9	216,406.2	192,159.3	(24,246.9)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,637,141.6	7,741,497.5	8,875,055.1	7,681,867.1	(1,193,188.0)
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,082,682.1	4,967,119.0	6,024,828.9	5,300,037.9	(724,791.0)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	559,649.5	546,383.1	662,731.2	583,941.4	(78,789.8)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,743.8	106,499.4	108,000.0	79,745.3	(28,254.7)
Хангамж, бараа материалын зардал	1,345,800.3	1,397,000.0	1,390,000.0	1,268,640.6	(121,359.4)
Нормативт зардал	49,281.9	50,000.0	50,000.0	50,119.6	119.6
Эд хогшил, урсгал засварын зардал	400,226.4	574,496.0	544,495.0	314,637.7	(229,857.3)
Томилолт, зочны зардал	99,757.6	100,000.0	95,000.0	84,744.6	(10,255.4)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	103,523.0	101,346.9	81,106.7	69,843.1	(11,263.6)
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,000.0	5,000.0	1,995.0	(3,005.0)
Тээврийн хэрэгслийн татвар	13,366.0	13,653.8	13,653.8	13,897.9	244.1
Газрын төлбөр	73,017.5	68,421.3	45,000.0	44,011.4	(988.6)
Банк, СБ-ын үйлчилгээний хураамж	185.7	400.0	400.0	242.4	(157.6)
Үл хөдлөх хөрөнгө татвар	7,363.8	7,363.8	10,544.9	9,696.4	(848.5)
Сургалт семинар	9,590.0	6,508.0	6,508.0		(6,508.0)
Бараа үйлчилгээний бусад зардал	1,183.0	10,000.0	5,000.0	200.0	(4,800.0)
Бараа үйлчилгээний бусад зардал	1,183.0	10,000.0	5,000.0	200.0	(4,800.0)
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	51,393.8	117,000.0	130,299.5	122,116.2	(8,183.3)
Шагнал урамшуулал баяр ёслол	17,463.8	17,000.0	25,000.0	21,657.8	(3,342.2)



Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ	3,220.0		2,000.0	2,000.0	-
Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ			3299.5	3,299.5	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,710.0	100,000.0	100,000.0	95,158.9	(4,841.1)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				1,640,495.9	1,640,495.9
ҮХ дотоод хөдлөлийн борлуулалтын гарз				470,073.5	470,073.5
Үндсэн хөрөнгийн элэгдэл	2,646.4			1,145,702.4	1,145,702.4
Даатгалын үйлчилгээ	100,265.4			24,720.0	24,720.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР					
Санхүүжилтийн орлого ИНЕГ-аас				4,790,786.8	
Хүүгийн орлого				3,587.6	
Борлуулалтын орлого дүн				2,878,170.5	
Газрын техник үйлчилгээний орлого				2,071,263.6	
Шатахуун тээврийн орлого				709,213.0	
Борлуулалтын орлого				661.2	
Үйл ажиллагааны бусад орлого				5,983.4	
Хойшлогдсон орлого				91,049.3	
БАЙГУУЛЛАГЫН ТОО		0	0	1	0
Төсвийн байгууллага				1	
Төсвөөс гадуур байгууллага					
АЖИЛЛАГСДЫН ТОО	0	0	0	269	0
Удирдах ажилтан				9	
Гүйцэтгэх ажилтан				92	
Үйлчлэх ажилтан				168	
Гэрээт ажилтан					



Төсвийн гүйцэтгэлийн тохируулга

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Нэр	Төсөв 2017	Гүйцэтгэл		Тохируулсан	Төсвийн гүйцэтгэл 2017		Хувиар
	Дүн /төг/	Зардал	Орлого	Тохируулга	Зардал	Орлого	
Борлуулалтын орлого			1,849,000.0			2,878,170.5	155.7
Газрын техник үйлчилгээний орлого			1,350,000.0			2,071,263.6	153.4
Шатахуун тээврийн орлого			495,000.0			709,213.0	143.3
Бусад борлуулалтын орлого						661.2	
Үйл ажиллагааны бусад орлого			4,000.0			5,983.4	149.6
Хойшлогдсон орлого						91,049.3	
Нийт зарлага	7,969,844.4	7,874,026.3		9,091,461.3	7,874,026.3		86.6
Бараа, үйлчилгээний зардал	7,838,972.6	7,742,213.7		8,944,108.9	7,742,213.7		86.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	4,967,119.0	5,300,037.9		6,024,828.9	5,300,037.9		88.0
Үндсэн цалин	4,380,658.0	4,708,094.9		5,427,550.9	4,708,094.9		86.7
Унаа хоолны хөнгөлөлт	586,461.0	591,943.0		597,278.0	591,943.0		9.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	546,383.1	583,941.4		662,731.2	583,941.4		88.1
Тэтгэврийн даатгал				421,738.0			-
Тэтгэмжийн даатгал				60,248.3			-
ҮОМШ-ийн даатгал				48,198.6			-
Ажилгүйдлийн даатгал				12,049.7			-
Эрүүл мэндийн даатгал				120,496.6			-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,499.4	79,745.3		108,000.0	79,745.3		73.8
Гэрэл, цахилгаан	35,000.0	33,828.4		35,000.0	33,828.4		96.7
Түлш, халаалт	53,999.4	24,000.7		50,000.0	24,000.7		48.0
Цэвэр, бохир ус	17,500.0	21,916.2		23,000.0	21,916.2		95.3
Хангамж, бараа материалын зардал	1,397,000.0	1,268,640.6		1,390,000.0	1,268,640.6		91.3
Бичиг хэрэг	25,000.0	27,812.0		30,000.0	27,812.0		92.7
Тээвэр, шатахуун	1,310,000.0	1,203,401.8		1,310,000.0	1,203,401.8		91.9
Шуудан, холбоо,интернэтийн төлбөр	15,000.0	8,598.1		15,000.0	8,598.1		57.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал	32,000.0	22,336.4		25,000.0	22,336.4		89.3

ИНЕГ-ын харьяа Газрын тусгай үйлчилгээний албаны 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000.0	6,492.3		10,000.0	6,492.3		64.9
Нормативт зардал	50,000.0	50,119.6		50,000.0	50,119.6		100.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.0	50,119.6		50,000.0	50,119.6		100.2
Эд хогшил, урсгал засварын зардал	574,496.0	314,637.7		544,495.0	314,637.7		57.8
Багаж, техник, хэрэгсэл	-	305,907.9		520,070.0	305,907.9		58.8
Барилга	74,740.0	69,546.5		74,740.0	69,546.5		93.1
Тоног төхөөрөмжийн	10,001.0	9,446.4		10,000.0	9,446.4		94.5
Автомашин	460,070.0	224,128.3		430,070.0	224,128.3		52.1
Гал унтраах зардал	5,260.0	2,786.7		5,260.0	2,786.7		53.0
Хөдөлмөр хамгаалалын хэрэглэл	24,425.0	8,729.8		24,425.0	8,729.8		35.7
Томилолт, зочны зардал	100,000.0	84,744.5		95,000.0	84,744.5		89.2
Дотоод албан томилолт	100,000.0	84,744.5		95,000.0	84,744.5		89.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,475.1	60,146.7		64,053.8	60,146.7		93.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000.0	1,995.0		5,000.0	1,995.0		39.9
Тээврийн хэрэгслийн татвар	13,653.8	13,897.9		13,653.8	13,897.9		101.8
Газрын төлбөр	68,421.3	44,011.4		45,000.0	44,011.4		97.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	400.0	242.4		400.0	242.4		60.6
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.0	200.0		5,000.0	200.0		4.0
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.0			5,000.0			-
Зар сурталчилгааны зардал		200.0			200.0		
Үл хөдлөх хөрөнгийн татвар	7,363.8	9,696.4		10,544.9	9,696.4		92.0
Сургалт семинар	6,508.0			6,508.0			-
Дотоод сургалт	6,508.0			6,508.0			-
Гадаад сургалт	-			-			
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалт, дэмжлэг	117,000.0	116,816.7		125,000.0	116,816.7		93.5
Нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг	100,000.0	95,158.9		100,000.0	95,158.9		95.2
Шагнал урамшуулал, баяр ёслол	17,000.0	21,657.8		25,000.0	21,657.8		86.6
Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ	-	2,000.0		2,000.0	2,000.0		100.0
Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ		3,299.5		3,299.5	3,299.5		100.0
ҮХ дотоод хөдлөлийн борлуулалтын гарз		470,073.5			470,073.5		
Үндсэн хөрөнгийн элэгдэл		1,145,702.4			1,145,702.4		
Даатгалын үйлчилгээ	-	24,720.0		-	24,720.0		

